

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Сэтгэлээ боловсруулах нь

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 203 (2022.08)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Панасоник компанийг үүсгэн байгуулагч Мацүшита Кооносүкэ гуай ямар ч хүний яриаг “Аан, тийм үү” гээд толгой дохин үнэн сэтгэлээсээ сонсдог хүн байсан. Он жилийн урсгалд арвин туршлага хуримтлуулсан, сэтгэл талбиун, уян зөөлөн тийм л хүнийг харахаар хайрлаж хүндэтгэх сэтгэл төрдөг юм.

Шагжамүни бурхан өглөг цуглуулж яваад брахман шашинтан нэгэн тариачны гэрийн үүдэнд очин зогсоход гэрийн эзэн “Би газар хагалан үр тарьж хоолоо олж иддэг. Чи ч гэсэн газар хагалж тариа тарьж идвэл яасан юм бэ?” гэж хэлжээ. Шагжамүни бурхан “Би ч бас газар хагалж, тариа тарин хоолоо олж иддэг” гэж хариулав. Тариачин дуугаа өндөрсгөн “Гэхдээ бид чамайг газар хагалж тариа тарьж байхыг хараагүй юм байна” гэтэл тэрээр “Би хүмүүсийн сэтгэлийг боловсруулж, итгэлийн үрийг цацдаг билээ” гэж хариулжээ.

Бид үргэлж зүрх сэтгэлээ боловсруулж байх чухал. Ингэснээр эргэн тойрноо хэзээд уян зөөлөн сэтгэлээр хүлээн авч, бусдыг чин сэтгэлээсээ сонсдог болдог. Тэр үед хүмүүс аяндаа таны эргэн тойронд цуглан ирэх болно.

Сайхан харилцааны түлхүүр нь сайн сонсогч байх гэж хэлдэг ч гэлээ юм үзэж нүд тайлсан төлөвшсөн хүний хувьд уян зөөлөн сэтгэл нь үнэт эрдэнэ билээ.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X282-283

Жинхэнэ өөрөөрөө амьдрах “Хичээнгүй” 2-р хэсэг



Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Бүх хүн дэлхийн бөмбөрцөг дээрх нэг цэг

“Энд нэг дэлхийн бөмбөрцөг байна гэж бодъё. Түүн дээр нэг цэг тэмдэглэе. Хүмүүс бид бол бөмбөрцөг дээр тэмдэглэсэн цэг л гэсэн үг.” Энэ бол Зэн урсгалын ламтан, сэлмийн урлагийн мастер агсан Оомори Соогэн (1904-1994)-ы үг. Энэ үг “Дэлхийн бөмбөрцгийн хаана нь ч цэг тавьсан тэр цэг төв нь болдог. Төв нь болохгүй цэг гэж нэг ч байхгүй. Хэдэн зуун сая цэг тавьсан ч адилхан. Гэхдээ бөмбөрцөг ганцхан л байдаг.” гэж үргэлжилдэг. Хачирхалтай гэмээр илэрхийлэл боловч энэ үг хүмүүс бидний жинхэнэ дүр төрхийг илтгэдэг.

Дэлхийн бөмбөрцгийн гадаргуу дээр зогсох хүн бүхэн бөмбөрцгийн төвд зогсох үнэмлэхүй оршихуй. Гэхдээ тэд нар, ус, агаар гээд бүхий л юмс, өөрөөсөө бусад хүмүүсийн ачаар амьдардаг тул бусадтай нэгэн бүхэл юм.

Үүнийг сансар огторгуйн хүрээнд бүхэлд нь аваад үзсэн ч, дэлхий нийгэм, гэр бүл гэсэн жижиг нэгж дээр аваад үзсэн ч ялгаагүй. Аав нь гэрийн гол хүн, хүүхэд нь жижиг орон зай гэсэн юм байхгүй, гэр бүлийн гишүүн бүр өөр өөрийн онцлогтой, давтагдашгүй оршихуй бөгөөд гэр бүл, эргэн тойрныхоо хүмүүсийн учрал холбоогоор дамжуулан харилцан бие биенээ тэтгэн амьдардаг.

Шагжамүни буддагийн хэлсэн “Тэнгэр газар дээр зөвхөн би ариун нандин оршихуй” хэмээх үг үүнийг илэрхийлдэг. Хүн бүр агуу нэгэн бүхэл дэлхий ертөнцийн үнэмлэхүй, давтагдашгүй нандин оршихуй гэсэн үг. Нөгөөтэйгүүр буддизмд хүн гэдэг бол сансар огторгуй, дэлхий ертөнцийн нэгэн иргэн бөгөөд бүгд нэг бүхлийн нэг хэсэг гэдэг утгаараа нэг амьтай ах дүүс, эгч дүүс хэмээн хүний жинхэнэ мөн чанарыг тодорхойлдог.

Зургаан барамидын хичээнгүйн барамид гэдэг нь ийнхүү бусдын ачаар амьдарч байгаадаа талархаж, бусдын ачийг мартахгүй байхыг сануулдаг үйл юм. Хүн өөрийгөө хүндэлж хайрладаг шигээ бусдын зовлон гунигийг хуваалцан энэрэн хайрлаж, зовж шаналж буй хүнд хэзээд тусламжийн гараа сунгадаг хүн болох нь хичээнгүйн барамидыг хэрэгжүүлэхийн гүн гүнзгий ач холбогдол гэж би боддог юм.

Бусдын ачийг олж харцгаая

Тус сэтгүүлийн өнгөрсөн сарын дугаарт бусдын төлөө сайн үйл хийх, сүсэгтэн хүний хийх ёстой мэдээжийн зүйлийг мэдээжийн юм шиг хийх нь хичээнгүйн барамид гэж би хэлсэн. Энэ үйлийг үргэлж талархсан сэтгэлээр хэрэгжүүлэхэд өдөр тутамдаа “талархмаар зүйл”-ийг хэр их олж анзаарч чадаж байна вэ гэдэг чухал.

Ихэнх хүмүүс өөрсдийгөө төгс хүн гэж боддоггүй болов уу. Тийм ч учраас бурханы үйлд хичээн шамдъя хэмээн үргэлж сурч мэдэхийн төлөө зорьдог. Бид бурханы номтой учирсны ачаар бурханы үйлийг хэрэгжүүлэхийн чухлыг мэдэж авсан. Гэхдээ бодит байдал дээр гэр бүл, хамаатан садан, найз нөхөд, танил гээд санга, номын нөхдийн ачаар бурханы сургаалыг сурч мэдсэн гэж хэлж болно. Тиймээс эхлээд ойр дотны хүмүүстэй талархаж, номын нөхдөөсөө суралцангаа жижиг ч болов талархмаар зүйлийг олж харж, түүнийгээ үйл хөдлөлөөрөө илэрхийлээд үзвэл ямар вэ?

“Талархмаар зүйл”-ийг хаанаас олж харах вэ гээд бодоод үзэхээр манай нийгэмлэгийн гишүүний илтгэл бол ёстой л эрдэнэсийн сан гэсэн үг. Гишүүний илтгэлээр гишүүд зовлон бэрхшээлээсээ ангижирах хүсэл тээн нийгэмлэгтэй учирч, улмаар бурханы сургаалыг сурч мэдэн зовлонгийн шалтгаан нь өөрийн эндүү ташаа ойлголт, буруу харах өнцөгт байсныг ухаарч, амьдралаа өөрчилсөн талаараа илэн далангуй ярьж сэтгэлээ хуваалцдаг. Мөн гишүүний илтгэл бол олны ачаар амьд яваагаа мартах шахсан явсан хүн сураалын ачаар бүх зүйлс талархмаар сайхан зүйлс байсныг ухааран, талархаж амьдрах амьдралыг сонгосон талаарх түүх юм. Мөн бидний сүсэг бишрэл үнэ цэнэтэй зүйл гэдгийг баталдаг.

Өнөөг хүртэлх амьдрал, хандлагаа бурханы сургаалын дагуу эргэн харах үед бид маш олон зүйлийн ач буяныг анзаарч, хэн нэгэнд тусалж, хэн нэгнээс тусламж аван амьдарч байгаа өөрийгөө олж хардаг. Тийм учраас гишүүний илтгэл гэдэг бол жинхэнэ өөрөөрөө амьдрахыг ухааруулах маш чухал бурханы үйлийн нэг юм. Үүсгэн байгуулагч “Баяр хөөрөө хуваалцах нь бусдын сэтгэлд ч гэсэн баяр хөөрийг үрслүүлдэг” гэж хэлсэн байдаг шиг гишүүний илтгэл бол өөрийн баяр баяслаар дамжуулан номын анд нөхөддөө баяр хөөрийг бэлэглэх хайр энэрэл дүүрэн буяны үйл юм.

Эцэст нь хүн төрөлхтөн амар тайван унтах боломжтой дэлхий ертөнцийг бий болгохын төлөө зорьж, түүний төлөө залбиран хичээнгүйн барамидыг хамтдаа хэрэгжүүлцгээе хэмээн уриалж байна.

“Косей” сэтгүүл, 8-р сарын дугаар

Рисшо Косей Кай Нийгэмлэг

(Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Анхны номлол



Шагжамүни бурхан өөрийн ухаарсан үнэнийг дэлгэрүүлэхээр Варанаси хотын захын Сарнат хэмээх газар руу очив. Тэнд урьд нь хамт бясалгал хийж байсан 5 нөхөд нь байлаа.

Тэд эхэндээ Шагжамүни бурханыг хүнд бясалгалаас зугтсан хэмээн үл тоосон боловч түүний гэрэл цацарсан дүрийг хараад өөрийн эрхгүй толгойгоо бөхийлгөн хүндэтгэлтэйгээр угтан иржээ. Тэгээд сургаалыг нь сонсоод сэтгэл хөдлөн шавь оров. Тэр үед Шагжамүни бурхан Төв үзэл, Хутагтын дөрвөн үнэн, Хутагтын найман мөр сургаалыг айлдсан юм. Энэхүү анхны номлолыг “Анхны номын хүрдийг эргүүлсэн түүх” гэж хэлдэг.



Бяцхан мэдлэг


Шагжамүни бурхан эхэндээ өөрийн ухаарсан ойлгоход бэрх үнэнийг түгээх эсэхдээ эргэлзэж байсан боловч төөрөгдөлд автсан хүмүүсийг аврахын төлөөх нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс сургаалаа түгээхээр шийджээ. Үүний ачаар одоо бид



Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Сургаалаа түгээн дэлгэрүүлсэн нь




Шагжамүни бурхан гэгээрлийг олсноос хойш таалал төгсөх хүртлээ 45 жилийн турш голчлон Энэтхэгийн зүүн хойд хэсгээр тойрон алхаж сургаалаа түгээжээ.

Тэдгээрээс Шагжамүни бурхантай гүнзгий холбоотой газруудыг буддын шашны ариун дагшин газар болгон тэр хэвээр нь үлдээсэн байна. Үүнд түүний төрсөн газар Лүнбини, бурханы хутгийг олсон газар Бодьгаяа, анх сургаалаа заасан Варанаси хотын Сарнат, нирваан дүр үзүүлсэн Күшинагар зэрэг газрууд ордог. Үүнээс гадна Грикагуд уул, Жетавана хийд зэрэг түүхт газрууд бий.

Бяцхан мэдлэг

Жетавана хийд бол Шагжамүни бурханы шавь нараа сургаж байсан гол хийд байсан. Энэтхэгт хавраас зуныг хүртэл 3 сарын турш борооны улирал үргэлжилдэг тул лам хуврагууд гадуур гарахаас зайлсхийн бөөнөөрөө амьдран бурханы номд шамдан суралцдаг байжээ.



Олон улсын хэлтсийн даргын булан

Нивано ерөнхийлөгчийн бодьсадвагийн үйл

Цэцэг навч ид дэлгэрсэн 8-р сар ирлээ. Номын андууд та бүхэн маань өөр өөрсдийнхөө оронд нийгэмлэгийн үйл ажиллагаагаар дамжуулан өдөр бүрийг бурханы үйлд шамдан өнгөрөөж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Цагаан лянхуа судар бол “бодьсадва” хүнд зориулсан сургаал. Бид багагүй хугацаанд Нивано ерөнхийлөгчөөс Зургаан барамидын сургаалыг сонсож байгаа билээ. Түүний айлдвар бүрээс үргэлж биднийг жинхэнэ бодьсадва болж өсч хөгжөөсэй, өөртөө болон өрөөл бусдад аз жаргалыг өгч, эв найрамдал бүхий дэлхий, нийгмийг бүтээхийн төлөө бурханы үйлд хичээгээсэй хэмээн итгэж найдаж байгаа нь мэдрэгддэг.

Энэ сарын айлдварын эхний хагаст хүний оршин тогтнох утга учрыг сансар огторгуйн өнцгөөс нарийн тайлбарласан бол айлдварын сүүлийн хагаст эгэл сүсэгтэн хүний байр сууринаас талархууштай зүйлсийг анзааран харж, талархсан сэтгэлээ бусдын төлөө үйлээр дамжуулан бодит амьдралдаа хэрэгжүүлэхийн чухлыг айлдсан.

Сүүлийн үед Нивано ерөнхийлөгчийн сар бүрийн айлдвар нь бидний бурханлаг чанарт итгэн мөргөх түүний бурханлаг мөн чанарт мөргөх үйл мэт санагддаг болоод байгаа. Та бүхэнд тэгж санагдахгүй байна уу?


Кэйичи Акагава



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
(Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
(Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
Email: info@rkina.org
URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
Email: dharmasanantonio@gmail.com
URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

Korean Rissho Kosei-kai of Busan

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan

台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata

89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

Rissho Kosei-kai Ramu

Rissho Kosei-kai Aburkhil

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroov-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: https://www.rkuk.org
Facebook: https://www.facebook.com/rkuk.official
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: http://www.ibt-rk.org